



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ ТӨХК-ИЙН 2020 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/47/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер Ц.Хосжаргал  
Утас: 261885 Цахим хаяг: [khosjargalts@audit.gov.mn](mailto:khosjargalts@audit.gov.mn)  
Аудитор Д.Мөнхжин  
Утас: 260512 Цахим хаяг: [munkhjind@audit.gov.mn](mailto:munkhjind@audit.gov.mn)  
Аудитыг гүйцэтгэсэн: "Ниямазон аудит" ХХК  
Утас: 70145906 Цахим хаяг: [audit@nmz.mn](mailto:audit@nmz.mn)

Улаанбаатар хот  
2021 он

# **САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	9
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	11
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	13
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа .....	14
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.10. Аудитын илрүүлэлт.....	15
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН  
СТАНЦ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Л.ЭРХБААТАР ТАНАА

2024.03.15 № 07/906  
танай -ны № -т

### Аудитын санал дүгнэлт

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Байгууллагын техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн 14 үзүүлэлтээс 13 нь бүрэн биелж, 1 үзүүлэлт 98.7 хувийн, нийт 100.4 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ





**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	767,220,334.10	1,059,411,683.13
1.1.2	Дансны авлага	3,318,306,053.06	3,584,343,053.29
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	5,613,109.83	0.00
1.1.6	Бараа материал	3,248,731,434.00	3,277,531,634.22
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	797,486,132.32	1,143,795,944.78
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>8,137,357,063.31</b>	<b>9,065,082,315.42</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	64,636,521,468.81	63,472,763,972.12
1.2.2	Биет бус хөрөнгө	20,992,277,674.76	21,167,067,099.32
1.2.10	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>85,628,799,143.57</b>	<b>84,639,831,071.44</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>93,766,156,206.88</b>	<b>93,704,913,386.86</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	221,524,127.16	898,983,325.76
2.1.1.3	Татварын өр	0.00	1,509,046.54
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,979,546,804.47	120,051,286.45
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,150,582.40	3,797,922.15
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>7,203,221,514.03</b>	<b>1,024,341,580.90</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	5,469,411,697.62
2.1.2.6	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>0.00</b>	<b>5,469,411,697.62</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>7,203,221,514.03</b>	<b>6,493,753,278.52</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	19,447,456,792.53	19,447,456,792.53
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	59,135,050,898.37	59,135,050,898.37
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	20,734,205,000.00	20,937,713,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(12,753,777,998.05)	(12,309,060,582.56)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>86,562,934,692.85</b>	<b>87,211,160,108.34</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>93,766,156,206.88</b>	<b>93,704,913,386.86</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>39,760,079,946.36</b>	<b>41,134,179,660.78</b>
2	Борлуулалтын өртөг	34,987,956,324.18	36,888,813,263.86
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>4,772,123,622.18</b>	<b>4,245,366,396.92</b>
4	Түрээсийн орлого	5,183,999.99	33,210,021.64
5	Хүүний орлого	34,653,886.56	56,649,316.11
8	Бусад орлого	923,131,511.49	1,513,545,811.58
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,640,850,393.00	3,829,568,245.69
10	Ерөнхий ба удирдлагын зардал	974,160,243.91	1,169,811,350.66
12	Бусад зардал	167,137,943.64	255,987,393.31
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(7,150,866.64)	0.00
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)</b>	<b>945,793,573.03</b>	<b>593,404,556.59</b>
19	Орлогын татварын зардал	104,162,258.65	49,908,272.86
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>841,631,314.38</b>	<b>543,496,283.73</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)</b>	<b>841,631,314.38</b>	<b>543,496,283.73</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>841,631,314.38</b>	<b>543,496,283.73</b>



### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000.00	(13,543,825,000.63)	85,772,887,690.27
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				841,631,314.38	841,631,314.38
Зарласан ногдол ашиг				(51,584,311.80)	(51,584,311.80)
<b>2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,734,205,000.00	(12,753,777,998.05)	86,562,934,692.85
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			203,508,000.00		203,508,000.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				543,496,283.73	543,496,283.73
Өмчид гарсан өөрчлөлт				(14,615,736.80)	(14,615,736.80)
Зарласан ногдол ашиг				(84,163,131.44)	(84,163,131.44)
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	19,447,456,792.53	59,135,050,898.37	20,937,713,000.00	(12,309,060,582.56)	87,211,160,108.34

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2019 оны 12 дугаар сарын 31	2020 оны 12 дугаар сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	38,201,333,520.54	40,188,099,648.63
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	38,066,219,389.80	40,103,754,195.74
	Бусад мөнгөн орлого	135,114,130.74	84,345,452.89
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	34,583,314,628.56	35,216,186,957.67
	Ажиллагчдад төлсөн	8,338,623,854.19	9,233,046,806.08
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,777,000,000.00	3,107,600,000.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	13,708,854,473.05	12,840,581,102.60
	Ашиглалтын зардалд төлсөн	1,874,052,279.42	1,854,015,616.02
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,334,073,630.54	5,365,421,258.01
	Татварын байгууллагад төлсөн	2,487,105,366.16	2,776,258,311.86
	Даатгалын төлбөрт төлсөн	9,199,065.05	9,999,566.84
	Бусад мөнгөн зарлага	54,405,960.15	29,264,296.26
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>3,618,018,891.98</b>	<b>4,971,912,690.96</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	34,653,886.56	56,649,316.11
	Хүлээн авсан хүүний орлого	34,653,886.56	56,649,316.11
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,946,080,636.51	4,652,207,526.60
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,876,308,692.51	4,629,208,822.60
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	69,771,944.00	22,998,704.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,911,426,749.95)	(4,595,558,210.49)
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	51,584,311.80	84,163,131.44
	Төлсөн ногдол ашиг	51,584,311.80	84,163,131.44
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	<b>(51,584,311.80)</b>	<b>(84,163,131.44)</b>
<b>5</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(344,992,169.77)</b>	<b>292,191,349.03</b>
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,112,212,503.87	767,220,334.10
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	767,220,334.10	1,059,411,683.13



**2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилгот түвшний гүйцэтгэл**

2020 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
	Үйлдвэрлэсэн: Цахилгаан эрчим хүч	мян.кВтц	163,358.7	158,883.8	158,197.2	(686.6)	99.6%
1	Үйлдвэрлэсэн: Дулааны эрчим хүч	Гкал	604,443.0	612,891.1	620,329.0	7,437.9	101.2%
2	Түгээсэн: Цахилгаан эрчим хүч	мян.кВтц	133,697.8	129,243.5	128,991.7	(251.8)	99.8%
	Түгээсэн: Дулааны эрчим хүч	Гкал	580,833.0	586,715.0	589,609.0	2,894.0	100.5%
	<b>Нийт орлого</b>	мян.төг	<b>40,723,049.4</b>	<b>42,564,918.7</b>	<b>42,737,584.8</b>	<b>172,666.1</b>	<b>100.4%</b>
3	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	39,760,079.9	41,097,414.7	41,134,179.7	36,765.0	100.1%
	үйл ажиллагааны бус орлого	мян.төг	962,969.4	1,467,504.0	1,603,405.1	135,901.1	109.3%
	<b>Нийт зардал</b>	мян.төг	<b>39,777,255.8</b>	<b>42,564,918.7</b>	<b>42,144,180.3</b>	<b>(420,738.4)</b>	<b>99.0%</b>
4	Үүнээс: Ерөнхий ба удирдлагын зардал	мян.төг	1,098,463.6	1,221,934.8	1,166,422.1	(55,512.7)	95.5%
5	Татварын өмнөх ашиг	мян.төг	945,793.6		593,404.5	593,404.5	
6	<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	мян.төг	<b>841,631.3</b>		<b>543,496.2</b>	<b>543,496.2</b>	
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	84,163.1			-	
8	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг	1.0	1.0	1.0	0.0	99.0%
9	Нийт авлага	мян.төг	3,318,306.1	5,511,250.0	3,584,343.1	(1,926,906.9)	65.0%
	Нийт өглөг	мян.төг	7,203,221.5	7,657,400.0	6,493,753.3	(1,163,646.7)	84.8%
10	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	7,203,221.5	2,140,000.0	1,024,341.6	(1,115,658.4)	47.9%
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг		5,517,400.0	5,469,411.7	(47,988.3)	99.1%
11	Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	мян.төг	3,878,797.8	5,575,900.0	4,385,136.2	(1,190,763.8)	78.6%
12	Нийт ажиллагсдын тоо	хүн	454	450	450	-	100.0%
13	Нийт цалингийн сан	мян.төг	10,565,493.8	11,619,845.8	11,608,218.5	(11,627.3)	99.9%
14	нэг ажиллагчийн дундаж цалин	төг	1,939,334.4	2,151,823.3	2,149,670.0	(2,153.2)	99.9%



### 3.Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд авлагын нягтлан бодох бүртгэлийн програмыг шинэчлэн өөрчлөх, хөгжлийн бэрхшээлтэй ажилтны хөдөлмөрийн гэрээг хуулинд нийцүүлэн байгуулах, худалдан авах гэрээний дагуу үлдсэн чанарын баталгааг бусад богино хугацаат өр төлбөрөөр бүртгэх зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан байна.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 23-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Ниямазон аудит ХХК-ийн захирал З.Цээнээ, аудитын менежер Ж.Батнасан, аудитор А.Сүхбаатар, аудиторын туслах С.Баяртогтох, Ц.Оюунтунгалаг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн 4/136-1 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд Эрдэнэтийн дулааны цахилгаан станцыг төрийн өмчит хувьцаат компани /ТӨХК/, үйл ажиллагааны чиглэлийг дулаан цахилгаан үйлдвэрлэх, дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах гэж заасан байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дүрэмд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.Үүнд:

- Цахилгаан үйлдвэрлэх;
- Дулаан үйлдвэрлэх;
- Дулаан түгээх;
- Дулаанаар зохицуулалттай хангах;
- Эрчим хүчний тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа;
- Даралтат сав шугам хоолойг ашиглах;
- Засвар үйлчилгээ хийх;
- Хууль тогтоомжоор хориглоогүй бизнесийн бусад үйл ажиллагаа эрхлэх;
- Тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа эрхлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /2019 оны 03 дугаар сарын 22-нд орсон өөрчлөлтүүд/
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2019 оны 03 дугаар сарын 22/



- Нийгмийн даатгалын тухай хууль /Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 420.0 мянган төгрөг болсон/
- Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль /2020 оны 12 дугаар сарын 31/
- 2020 оны 04 дүгээр сарын 29-нд батлагдсан Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
- Корона вируст халдвар /ковид-19/ цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 13-ны 211 тоот тогтоол
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2020 оны 10 дугаар сарын 481 дугаар тогтоол "Эрчим хүчний салбарын аж ахуйн нэгж, байгууллагад дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлах тухай"

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна. Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийгээгүй байна.

Тайлант онд тус байгууллагын дотоод хяналтын хэлтсээс 2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, зорилтот түвшингийн биелэлт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудитор хяналт шалгалт хийж, зөвлөмж өгч ажилласан байна.

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар буюу 291.1 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт орлого 42,737.6 сая төгрөгийн 1 хувиар 427.4 сая төгрөгөөр тогтоосон нь суурь үзүүлэлтийн дүнг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс тооцсонтой холбоотой.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 61.3 сая төгрөгөөр буюу 0.06 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	767.2	1059.4	292.2
Авлага	3,323.9	3,584.3	260.4



**Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Урьдчилгаа	797.5	1,143.8	346.3
Бараа материал	3,248.7	3,277.5	28.8
Үндсэн хөрөнгө	85,628.8	84,639.8	(989.0)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>93,766.2</b>	<b>93,704.9</b>	<b>(61.3)</b>
Өр төлбөр	7,203.2	6,493.7	(709.5)
Эздийн өмч	86,562.9	87,211.2	648.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>93,766.2</b>	<b>93,704.9</b>	<b>(61.3)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,059.4 сая төгрөг болж 292.2 сая төгрөгөөр өссөн нь төлөвлөснөөс орлогыг 172.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, зардлыг 420.8 сая төгрөгөөр хэмнэж, ашиг, алдагдалгүй ажиллах төлөвлөгөөтэй байсныг 593.4 сая төгрөгийн татварын өмнөх, 543.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласнаас шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 3,584.3 сая төгрөг болж 260.4 сая төгрөгөөр өссөн нь цар тахлын улмаас аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн чадавхи муудсан, төрөөс хариуцан төлөх дулааны эрчим хүчний борлуулалтын 12 дугаар сард үүссэн 211.2 сая төгрөгийн авлага он дамжснаас шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд 2018-2019 онуудад үүссэн 39,5 сая төгрөгийн 4 байгууллагаас авах авлага байна. Энэ нь шүүхийн шийдвэр гарсан, шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжсэн дулааны эрчим хүчний авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 1,143.8 сая төгрөг нь цахилгаан эрчим хүчний төлбөрт Диспетчерийн үндэсний төвөөс төмөр замын тээврийн хөлсөнд дундын тооцоогоор хаасан 630.2 сая төгрөг, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан үндсэн хөрөнгө бэлтгэхтэй холбоотой төлсөн албан татварыг хувь тэнцүүлэн хасагдуулах заалтын дагуу НӨАТ-ын авлага 286.4 сая, гэрээт ажлын урьдчилгаа төлбөр 122.5 сая, нүүрсний илүү төлөлт 13.9 сая төгрөгөөс бүрдэж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,277.5 сая төгрөг болж 28.8 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалтын төлөвлөгөөний дагуу авсан нүүрс болон мазутын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ. Өмнөх оноос 43.5 мянган тонн бага нүүрс худалдан авч, нүүрсний илчлэг сайн байсантай холбоотой 34,7 мянган тонн нүүрс бага зарцуулсан байна.

Тайлант онд худалдан авалтаар 16,101.5 сая төгрөгийн бараа материал орлогод авсан ба үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал байхгүй. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй.

Оны эцэст гэрээнд заасан хуваарийн дагуу 12 дугаар сард 35.0 мянган тн буюу 1,913.8 сая төгрөгийн нүүрсний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь өвлийн их ачааллын үед 20 хоногоос доошгүй нөөцтэй байх эрчим хүчний салбарын бодлогын дагуу 25 хоногийн нөөц бүрдүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 84,639.8 сая төгрөг болж 989.0 сая төгрөгөөр буурсан нь 4,855.7 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч 5,844.6 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь өөрийн хөрөнгө оруулалтаар 4,652.2 сая төгрөгийн хөрөнгө орлогод авч, 203.5 сая төгрөгийн 2 газрыг үнэлж бүртгэлд авснаар нийт 4,855.7 сая төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс үнэ төлбөргүй шилжүүлсэн хөрөнгө байхгүй, ТӨБЗГ-ын 2020 оны 05 дугаар сарын 306 дугаар тогтоол, 2020 оны 05 дугаар А-1/883 тоот албан бичгийн дагуу 62.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий үлдэгдэл өртөггүй хөрөнгийг акталсан байна.



Үүнээс: Биет бус хөрөнгө 21,167,1 сая төгрөг болж 174.8 сая төгрөгөөр өссөн нь 203.5 сая төгрөгийн 2 газрыг үнэлж бүртгэлд авсан, 23.0 сая төгрөгийн биет бус хөрөнгө орлогод авсан, биет бус хөрөнгийн элэгдэл, хорогдол 51,7 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,493.7 сая төгрөг болж 709.5 сая төгрөгөөр буурсан байна. Үүнд: Богино хугацаат өр төлбөр 1,024.3 сая төгрөг болж 6,178.9 сая төгрөгөөр буурч, Урт хугацаат өр төлбөр 5,469.4 сая төгрөг болсон нь улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг НББОУС 20-12-ын дагуу урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байсныг хойшлогдсон орлого болгон бүртгэснээс шалтгаалсан байна. Эрчим хүчний салбарт их хэмжээний хөрөнгийн элэгдлийн зардал нь эрчим хүчний үнэ тарифт нөлөөлөхүйц гэж үзэн улсын төсвийн хөрөнгө оруулалтыг орлогын аргаар бичихийг зөвлөдөг байна.

Бусад богино хугацаат өр төлбөрийн 120,1 сая төгрөг нь дулааны эрчим хүчний урьдчилж орсон орлого, бусад нь хугацаанд нь төлөх дансны өр төлбөр байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 87,211.2 сая төгрөг болж 648.3 сая төгрөгөөр өссөн нь өргөтгөлийн болон саам эмчилгээний газрыг үнэлж, бүртгэлд тусгаж эздийн өмчийн бусад хэсэгт тусгасны 203.5 сая, тайлант хугацаанд ашигтай ажилласны 543.5 сая, 2020 оны цэвэр ашгаас ногдол ашиг төлсөн 84.2 сая, 2019 оны агаарын бохирдлын төлбөрийг тайлант онд төлсний 14.6 сая төгрөгөөс тус тус шалтгаалжээ.

### 3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Эрхбаатар нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 27 дугаар тушаалаар Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг анх, 2020 оны 09 дүгээр сарын 18-ны 182, 11 дүгээр сарын 12-ны өдрийн 237 тушаалаар тус тус тодотгон баталсан байна.

Хүснэгт 2. 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 оны гүйцэтгэл	2020 оны		Зөрүү	/сая төгрөг/ Хувь
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
	Үйлдвэрлэсэн:Цахилгаан эрчим хүч	Сая. кВтц	163.4	158.9	158.2	(0.7)	99.6%
	Үйлдвэрлэсэн:Дулааны эрчим хүч	Мян.Гкал	604.4	612.9	620.3	7.4	101.2%
	Түгээсэн: Цахилгаан эрчим хүч	Сая. кВтц	133.7	129.2	129.0	(0.2)	99.8%
	Түгээсэн: Дулааны эрчим хүч	Мян.Гкал	580.8	586.7	589.6	2.9	100.5%
<b>2</b>	<b>Нийт орлого</b>	<b>сая.төг</b>	<b>40,723.0</b>	<b>42,564.9</b>	<b>42,737.6</b>	<b>172.7</b>	<b>100.4%</b>
	Үүнээс: Цэвэр борлуулалт	Сая .төг	39,760.1	41,097.4	41,134.2	36.8	100.1%
<b>3</b>	<b>Нийт зардал</b>	<b>Сая.төг</b>	<b>39,777.2</b>	<b>42,564.9</b>	<b>42,144.2</b>	<b>(420.7)</b>	<b>99.0%</b>
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		34,988.0	37,200.5	36,888.8	(311.7)	99.2%
	Ерөнхий ба удирдлагын зардал	Сая. төг	1,098.5	1,221.9	1,166.4	(55.5)	95.5%



4	Цэвэр ашиг, алдагдал Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт	Сая. төг	841.6	0.0	543.5	543.5	
		Сая. төг	3,878.8	5,575.9	4,385.1	(1,190.8)	78.6%

Тайлант онд зорилтот түвшнээр 42,564.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 42,564.9 сая төгрөгийн зардалтай, ашиг, алдагдалгүй байхаар төлөвлөсөн байна.

Тайлант онд 158.2 сая кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэн, 129.0 сая кВт.ц цахилгаан эрчим хүчийг 31,555.5 сая, 620.3 мянган Гкал дулаан үйлдвэрлэн, 589.6 мянган Гкал дулааныг 9,578.7 сая төгрөгөөр борлуулж, үйл ажиллагааны бус орлогоор 1,603.4 сая төгрөгийн орлого олж, нийт 42,737.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж төлөвлөгөөг 172.7 сая төгрөгөөр давуулсан байна. Төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нь дулааны орлогыг 39.2 сая төгрөгөөр, алданги, нэмэлт усны төлбөр зэрэг үйл ажиллагааны бус орлогыг 135.9 сая төгрөгөөр илүү төвлөрүүлснээс байна.

Нийт зардал гүйцэтгэлээр 42,144.2 сая төгрөг болж батлагдсан төлөвлөгөөнөөс 420.7 сая төгрөгөөр дутуу байна. Энэ нь өртөг бүрдүүлдэг 20 төрлийн зардлыг 340.2 сая төгрөгөөр, ерөнхий ба удирдлагын зардлыг 55.5 сая төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардлыг 25.0 сая төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Тайлант онд их засварын 50, хөрөнгө оруулалтын 55, техник зохион байгуулалтын арга хэмжээний 31 нийт 136 арга хэмжээнд 5,575.9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэлээр 4,385.1 сая төгрөг зарцуулж, төлөвлөсөн ажлаас их засварын 2 ажил 40-80 хувийн гүйцэтгэлтэй гарсан нь цар тахлын хорио цээрийн дэглэмийн улмаас материал хүлээгдснээс шалтгаалсан ба бусад ажлууд бүрэн хийгдсэн байна.

Тус компани 593.4 сая төгрөгийн татвар ногдуулах орлогод 49.9 сая төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулж, 543.5 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Төлөвлөснөөс нийт авлагыг 1,926.9 сая төгрөгөөр, нийт өглөгийг 1,163.6 сая төгрөгөөр бууруулсан байна.

### 3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 1, Эрчим хүчний яам 5, хараат бус 3, нийт 9 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2020 онд 9 удаа зохион байгуулж 9 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

2020 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны зардалд нийт 92.3 сая төгрөгийн төсөв батлагдсан байна. Гүйцэтгэлээр цалин, урамшуулал 80.0 сая, нийгмийн даатгалын шимтгэлд 10.9 сая, томилолтын зардал 0.3 сая нийт 91.2 сая төгрөгийн зардалтай, 1.1 сая төгрөгийн хэмнэлттэй ажиллажээ.

### 3.8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих 171 мэдээллээс 170 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

### 3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.



**Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	3	-	3	-	100
Нийт дүн	3	-	3	-	100

/сая.төг/

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6.7 сая төгрөгийн НӨАТ-гүй худалдан авалт хийсэн, 5 аж ахуйн нэгж, байгууллагатай хийсэн худалдан авалтын гэрээг сунгаагүй, чанарын баталгааг харилцан адилгүй суутгадаг, үйлдвэрлэлийн өртгийг тооцохдоо борлуулалт удирдлагын зардалтай холбоотой зардлыг өртөгт шингээн нэгжийн өртгийг өсгөж тооцсон зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн мөрөөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, худалдан авах 103 гэрээг зөвхөн НӨАТ төлөгчтэй байгуулсан, гэрээ байгуулах журмыг шинэчлэн, гэрээний сунгалтын талаар тусгаж, чанарын баталгааг 5 хувиар 1 жилийн хугацаатай авдаг болжээ.

**3.10. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 41.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Тус компаний ашиглаж буй Интерактив ХХК-ийн Diamond 5.0 програмын хөгжүүлэлт, СТОУС-ын өөрчлөлт, байгууллагын онцлог, татварын хууль тогтоомжийн өөрчлөлтийг програмд оруулж, хөгжүүлсэн эсэхийг дараагийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай гэж үзлээ.



#### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*1 Нягтлан бодох бүртгэлийн програм, тайлагналтай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

2020 оны 01-р сарын 01-нээс хэрэгжсэн Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар үндсэн хөрөнгийн элэгдлийг 25 жилээр тооцох мөн 17 дугаар зүйлийн 17.2-т "Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл хэсгийн дүнд элэгдэл, хорогдол тооцохгүй" гэсэн заалттай. Тус компаний ашиглаж буй Интерактив ХХК-ийн Diamond 5.0 програм нь үндсэн хөрөнгийн анхны өртөг, дахин үнэлгээний нэмэгдлийн дүн тодорхойгүй, нийлсэн дүнгээр тусгагдсан байснаас аудитын явцад дахин тооцооллыг хийж шалгахад их цаг шаардсан. Мөн элэгдэл тооцох, данснаас хасах зэрэг нь автоматаар хийгдэх боломжгүй, зарим тайлангуудыг эксел программд хөрвүүлэн боловсруулалт хийхэд хүндрэлтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн програмд тавигдах шаардлага"-ын 2 дугаар зүйлийн 2.9-д ... боловсруулалтыг автомаар хийдэг байх" гэсэнтэй нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, татварын бүртгэлд алдаа үүсэх эрсдэлтэй.

##### 1.3. Өгсөн зөвлөмж

Өнөөгийн нөхцөлд байгууллагын санхүү нягтлан бодох бүртгэлийн бүхий л үйл ажиллагааг хөнгөвчлөх, тэдгээр үйл ажиллагааг байгууллагын бүх салбар нэгжүүд дээр ижил стандартаар явуулах боломжтой цогц програм хангамжийг нэвтрүүлэх чиглэлд анхаарах нь зүйтэй гэсэн зөвлөмж өгөх

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 2. Балансын данстай холбоотой

##### 2.1. Илрүүлэлт:

2020 онд бараа ажил үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээний дагуу үлдсэн чанарын баталгааны 41.9 сая төгрөгийг дансны өглөгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт "бусад богино хугацаат өр төлбөрт ... худалдан авагчид болон ажиллагчдаас авсан буцаан төлөх мөнгөн барьцаа ... хэсэгт толилуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

##### 2.2. Эрсдэл:

Дансны өглөг буруу илэрхийлэгдэх

##### 2.3. Өгсөн зөвлөмж

Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан зааврын дагуу өр төлбөрийг ангилан бүртгэх зөвлөмж өгөх

##### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### *3. Зардлын данстай холбоотой*

#### 3.1. Илрүүлэлт:

Тус компанид ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй 12 ажилтны хөдөлмөрийн гэрээнд ажиллах цагийг 7 хоногт 40 цагаар тооцон хийж, 832 цагийн цалин хөлсийг нь илүү цагаар тооцон олгоогүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.1-д "... хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд 36 цаг хүртэл байна" гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.2. Эрсдэл:

Цалин хөдөлмөрийн хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал буруу илэрхийлэгдэх

#### 3.3. Өгсөн зөвлөмж

Хөгжлийн бэрхшээлтэй ажиллагсдын хөдөлмөрийн гэрээг шинэчлэн хийх, цалин хөлсийг зохих ёсоор тооцох

#### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020	Аудитын нэр: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2021/47/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Эрдэнэтийн дулааны цахилгаан станц ТӨХК		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тус компанийн ашиглаж буй Интерактив ХХК-ийн Diamond 5.0 програм нь үндсэн хөрөнгийн анхны өртөг, дахин үнэлгээний нэмэгдлийн дүн тодорхойгүй, элэгдэл тооцох, данснаас хасах зэрэг нь автоматаар хийгдэх боломжгүй, зарим тайлангуудыг эксел программд хөрвүүлэн боловсруулалт хийхэд хүндрэлтэй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрхбаатар Ч.Орхон
2	2020 онд бараа ажил үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээний дагуу үлдсэн чанарын баталгааны 41.9 сая төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөрт бус дансны өглөгөөр бүртгэсэн.	41.9	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрхбаатар Ч.Орхон
3	Тус компанид ажиллаж буй хөгжлийн бэрхшээлтэй 12 ажилтны хөдөлмөрийн гэрээнд ажиллах цагийг 7 хоногт 40 цагаар тооцон хийж, 832 цагийн цалин хөлсийг нь илүү цагаар тооцон олгоогүй байна.		Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал Ерөнхий нягтлан бодогч	Л.Эрхбаатар Ч.Орхон
<b>ДҮН</b>		<b>41.9</b>			





Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: [info@audit.gov.mn](mailto:info@audit.gov.mn)

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Хаяг: Засгийн газрын IV байр  
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг  
Улаанбаатар-15160, Монгол Улс